

**БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТАЛААРХ ОЛОН УЛСЫН
ТУРШЛАГА**





Энэхүү мэдээллийг бичил уурхайн үйл ажиллагааны олон улсын туршлагад үндэслэн бэлтгэв.

Удиртгал

Бичил уурхай нь дэлхий нийтийн хөгжлийн чухал асуудлын нэг болж байгаа бөгөөд өнөөдөр дэлхийн хөгжиж буй 70 гаруй оронд 40 сая хүн энэ үйл ажиллагааг эрхлэн, нийтдээ 150–170 сая хүний амьжиргааг дэмжин тэтгэж байна. Бичил уурхай нь хөдөөгийн иргэдэд ажлын байр бий болгохоос гадна орон нутгийн эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг.



Бичил уурхайн талаар сөрөг ойлголт өгдөг ерөнхий асуудлууд ба тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд

Хэдийгээр бичил уурхайн үйл ажиллагаа нь орон нутгийн эдийн засаг, хөдөөгийн иргэдийн амьжиригаанд хувь нэмэр оруулан олон талын зэрэг үр дүнг үзүүлдэг ч уг үйл ажиллагааг эрхэлж буй ихэнх хүмүүсийн зохион байгуулалтгүй ажилладагаас ялангуяа бодлого боловсруулагчид, нийгэм, олон нийтийн дунд сөрөг ойлголт байсаар байна. Гэхдээ энэ үйл ажиллагааг эрхэлж буй хүмүүс зохион байгуулалт (хэрэв тэд өөрсдөө сайн дураараа эвлэлдэн нэгдэхээр шийдэн)-нд орж ажилласан тохиолдолд эдгээр сөрөг ойлголт, хандлагыг өөрчилж болно. Бичил уурхайчдын дунд нийтлэг байдаг болон сөрөг ойлголт өгдөг асуудлууд бол тэд аль нэг засаг захиргааны харьялалд бүртгэлгүй, татвар төлдөггүй, ашигт малтмалын болон хөдөлмөрийн хууль зөрчдөг, эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг дагаж мөрддөггүй, ой цэвэр усны эх үүсвэр, хүрээлэн буй орчинг бохирдуулдаг, олборлолт явуулсан газартаа нөхөн сэргээлт хийхгүй орхидог явдал юм. Бичил уурхайн үйл ажиллагаа ихэнх тохиолдолд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартын гадна явагддаг, түүний ойр орчимд нийгмийн хүрээний ямар нэг зохион байгуулалт байдаггүй, байгаль орчны бохирдол ихтэй, эдгээр нөхцөл байдал нь эргээд тэдний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, аюул дагуулдаг. Түүнчлэн тэд татвараас зайлсхийж олборлосон ашигт малтмал, бүтээгдэхүүнээ ихэнхидээ хар зах дээр албан бус байдлаар борлуулдаг учраас бичил уурхай бүхий улс орнууд түүнээс ашиг орлого олж чаддаггүйгээс гадна орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр нь тооцогддоггүй.

Харин бичил уурхай эрхлэгчид зөв зохион байгуулалтанд орж ажилласнаар эдгээр асуудлыг шийдэж болно. Иймд



зохион байгуулалтанд орох нь уг үйл ажиллагааг албан ёсны болгох ажлын эхний бөгөөд чухал алхам юм. Хэрэв бичил уурхай эрхлэгчид холбогдох дүрэм журам, удирдамж чиглэлээ даган, татвар төлж, хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болбол бичил уурхайн талаарх дээрх сөрөг ойлголт, хандлагыг бодлого боловсруулагчид, олон нийтийн дунд өөрчилж, түүний олон ээрэг талууд түүнээс оруулж буй хувь нэмэр илүү тод харагдаж хүлээн зөвшөөрөгдөх болно. Нөгөө талаас бичил уурхай нь хөдөөгийн хүн ам/иргэдийн амьжиргаанд тодорхой хувь нэмэр оруулж байгаа ч үүнийг олон нийт сайн ойлгодоггүй нь бодлого боловсруулагчдын зүгээс бичил уурхайн үйл ажиллагааг хариуцлагагүй, албан бус үйл ажиллагаа гэж үздэгтэй ч холбоотой байж болно. Иймээс бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд орж, үйл ажиллагаагаа албан ёсны болгосноор бичил уурхайн талаарх олон нийтийн сөрөг ойлголт өөрчлөгджэй, бодлого боловсруулагчид, бусад олон улсын байгууллагуудын итгэл найдварыг олж авах нөхцөл бүрдэнэ.

Бичил уурхай эрхлэгчид яагаад зохион байгуултанд орох хэрэгтэй вэ?

Төр засгийн байгууллага, бусад холбогдох газрууд бичил уурхай эрхлэгч иргэдтэй нэг бүрчлэн уулзсанаас тэдний төлөөлөлтэй уулзаж ярилцан санал бодлыг сонсох нь илүү хялбар байдаг. Нөгөө талаас бичил уурхай эрхлэгчид нь тус тусдаа өөр өөрсдийн асуудлыг ярихаасаа илүүтэй дуу хоолойгоо нэгтгэн асуудлаа хамтдаа гаргаж тавих үедээ санал бодлоо илүү сайн хуваалцаж, ярилцаж чаддаг хүмүүс байдаг. Тэдний нэгэн зорилгын дор байгуулсан байгууллага нь гишүүдийнхээ ашиг сонирхлыг хамгаалах жишээлбэл: олборлолт явуулах газрын асуудал, уул уурхайн том компанийн тодорхой асуудлаар ярилцах, банкнаас зээл авах, үүссэн аливаа зөрчлийг шийдэх, зохицуулахад



туслах, гишүүддээ мэдээлэл өгөх зэргээр тэднийг дэмжин ажилладаг байна.

Бичил уурхайчид зохион байгуулалтгүй, албан бусаар ажилладаг учраас орон нутгийн засаг захиргаад тэдэнд орлогын албан татвар ногдуулан, хураан авч чаддаггүйн дээр тэдэнд шаардлагатай дэмжлэг тусламжийг хүргэх, тодорхой зохицуулалт хийхэд хүндрэл учирдаг. Татварын орлогыг бичил уурхайн үйл ажиллагаа тухайлбал газар дээрх үзлэг шалгалт, шаардлагатай дэд бүтцийг бий болгох зэрэгт дэмжлэг үзүүлэх хэлбэрээр зарцуулж болно. Бичил уурхай эрхлэгчдийн талаарх мэдээлэл тухайлбал хэдэн хүн, хаана хэрхэн олборлолт явуулж байгаа, ямар хүмүүс уг үйл ажиллагаанд ихэвчлэн оролцдог зэрэг наад захын мэдээлэл бодлого боловсруулагчдын дунд байдаггүй учраас зохицуулалтын орчин бүрдүүлэхэд хүндрэл учирдаг. Гэхдээ бүртгэл судалгааг явуулж байж эдгээр мэдээллийг бий болгосноор бусад шаардлагатай арга хэмжээг авах нөхцөл бүрдэнэ. Ер нь баттай сайн мэдээлэл нь уул уурхайн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, байгаль орчин, аюулгүй ажиллагааг хангах, холбогдох чиглэлийн сургалтын хэрэгцээг тодорхойлоход чухал ач холбогдолтой байна. Гана, Бразил, Филиппиний алт олборлогч иргэд зохион байгуулалтанд орж, өөрсдийн холбоо байгууллагаа байгуулан ажлын үнэмлэх бүхий албан ёсны ажилчид болж чадсан байна. Тэдний байгуулсан Холбоод нь өөрсдийн гишүүдийн өмнөөс холбогдох байгууллага, газруудтай тодорхой асуудлаар уулzan ярилцан асуудлаа шийдэхэд чухал үүрэгтэй ажиллаж байна.

Өмнөд америкийн орнуудад бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалттай албан ёсоор ажиллахыг чухалчилж үздэг, тухайн орнуудын төр засгийн байгуулагууд нь тэдэнтэй албан ёсны уурхайчид гэсэн байр сууринаас хандан шаардлагатай төрөл бүрийн үйлчилгээг хүргэдэг ажээ.



Жишээ нь: Гана Улсын Засгийн газар албан ёсны бүртгэлтэй уурхай ажиллуулж буй хүмүүст геологийн судалгааны тайлан, газрын зураг болон олборлолтын явцад гарч болох сөрөг нөлөөг бууруулах, хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар техникийн тусламж дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг.

Бичил уурхайчдын дунд идэвхитэй, бусдыг удирдан чиглүүлэх чадвартай хүн байж, холбогдох талуудтай уулзаж ярилцахад тэднийг удирдан чиглүүлдэг байх нь чухал.

Зохион байгуулалтын хэлбэрүүд, үүрэг:

Бичил уурхай эрхлэгчид үндэсний ба орон нутгийн аль ч түвшинд зохион байгуулагдаж болно. Орон нутгийн холбоод буюу ТББ-үүд нь бүсийн буюу үндэсний хэмжээний шүхэр байгууллагатай байж, Зөвлөлөө байгуулан уг зөвлөл нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, сургалт, мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зэрэг холбогдох асуудлаар ажиллах төлөөллийг багтаасан төрөл бурийн хороодтой байна. Ийм байгууллага нь орон нутгийн түвшинд үүсэн бий болж, уг зохион байгуулалтанд нэгдэн орж буй иргэд нь өөрсдийн дундаас удирдан чиглүүлэх чадвартай хүнээ ахлагчаар сонгодог байна. Уг байгууллага нь хариуцлагатай уул уурхайн зарчмыг баримтлан, оролцогч талуудын дэмжлэгийг авч, нөгөө талаас олборлолт явуулах газар, том уурхайтай хамтран ажиллах, хууль эрх зүй, зохицуулалтын орчин болон төр, хувийн хэвшлийн үйлчилгээг хослуулан авах зэрэгт анхаарлаа хандуулан ажилладаг. Тус шүхэр байгууллага нь орон нутагт өөрийн салбартай байна.



Эдгээр байгууллагуудын үндсэн чиг үүрэг:

Бичил уурхай эрхлэгчдийн байгууллага нь уг салбарт олон нийтийн дэмжлэгийг бий болгох, аливаа асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, уул уурхайн том компани ба бусад оролцогч талуудтай санал бодлоо хуваалцан хамтран ажилладаг. Түүнчлэн байгууллага нь өөрийн гишүүдийн аюулгүй ажиллагаа, нийгмийн баталгааг хангасан ажлын орчинг бий болгоход гол анхаарлаа хандуулдаг. Гишүүд нь уг шүхэр байгууллагаас өөрсдийг нь төлөөлөн төрийн холбогдох байгууллагуудтай харьцаан зээл авах, олборлолт ба зохион байгуулалтын асуудлаар шаардлагатай сургалтанд хамрагдах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг олон нийтийн хөгжлийн төсөл хөтөлбөрүүдтэй холбоо харилцаа тогтоон тэдний дэмжлэг тусламжийг олж авахад гол чиглэн ажилладаг байхыг хүсдэг. Уг байгууллага нь өөрийн гишүүдэд олборлолт, байгаль орчин, ашигт малтмалын үнэ, тоног төхөөрөмж нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчид, хамтран ажиллаж болох талуудын талаарх мэдээлэл хүргэх үүрэгтэй ажилладаг. Тухайлбал, Сюринэйимд бичил уурхай эрхлэгчдэд “зээл олгох сонирхолтой нэг ч банк санхүүгийн байгууллага байдаггүй” учир нь банк тэднээс олборлолт явуулж буй газруудын нөөц, санхүүгийн болон бизнес төлөвлөгөөгөө гаргаж өгөхийг шаарддаг ба тэд эдгээр мэдээллийг гаргаж өгч чадахгүй гэж үздэг байв. Иймд бичил уурхай эрхлэгчдийн Нэгдсэн холбоо санхүүгийн байгууллагуудтай уулзан бичил уурхай эрхлэгчдэд зориулсан зээлийн тусгай схем/багц гаргуулах талаар ярилцсан байна. Бичил уурхайн олборлолтын ажлын нөхцлийг сайжруулахад Бичил уурхайчдын Нэгдсэн холбоо нь хариуцлагатай уул уурхайн зарчимд тулгуурлан гол чухал асуудлуудаар оролцогч талуудыг хэлэлцээрийн ширээнд урьж ярилцаж чаддаг болсон байна. Үүний үр дүнд Сюринэйимд бичил уурхай эрхлэгчдэд зохион байгуулалтанд орсон, ороогүй

гэж ялгахгүйгээр төр засгийн зүгээс санхүүгийн буюу бусад төрлийн дэмжлэгийг үзүүлдэг болсон.



Бичил уурхайчдын төлөөлөлт Бичил Уурхайн асуудлаар олон улсын хуралд оролцож байгаа нь, Манила, 2010 он

Үр дүнтэй зохион байгуулалтыг бий болгоход гардаг саад, бэрхшээл:

- **Идэвхигүй сул байдал**

Олон хүмүүс ямар нэг байгууллагын гишүүн байхыг хүсдэг ч хэн нэгэн эсвэл аль нэг байгууллага, төрийн ба олон улсын байгууллага, орон нутгийн идэвхтэн хүн гарч ирэн “эхлүүлэх”-ийг хүлээж суудаг. Бичил уурхай эрхлэгчдийн дараах нийтлэг хандлагууд байдаг байна.Үүнд:

“Бид зохион байгуулагдах/зохион байгуулахыг хүсдэг ч биднийг удирдаж чиглүүлэх хүн байдаггүй”

“Ахлагч/удирдагч биднийг дагуулж бид түүнийг дагах ёстой”

“Бид энэ ажлыг эхлүүлэхийг хүсдэг ч бид зөв хүнээ



олж чадаагүй л байна Тохирох хүн хэзээ нэг цагт гарч ирж, бидэнд "эхэл" гэж хэлэх болно"

Бичил уурхайчдын байгууллага заримдаа гишүүдийнхээ төлөө юу хийх хэрэгтэй талаар сайн ойлголтгүй байдаг. Учир нь:

- **Мэдлэг/ноу хоу хангалтгүй байх**

Зохион байгуулах менежмент муу/хангалтгүй байдгаас санхүүгийн бүртгэл, тооцоо хөтлөлт хангалтгүй байх явдал гардаг.

- **Эв нэгдэл, итгэлцэл хангалтгүй байх**

Гишүүд эв нэгдэл муутай, тэдний дунд итгэлцэл байхгүй байх явдал гардаг. Зарим хүмүүс байгууллагыг гишүүдээсээ мөнгө хураадаг байгууллага гэж болгоомжилж байхад нөгөө хэсэг нь түүний удирдлагын хороо/удирдлагад итгэх итгэл сул байдаг.

- **Бичил уурхай эрхлэгчид байнга нүүж шилжилт хөдөлгөөн их**

Олборлолт явуулж буй иргэд нь байнга шилжиж нүүж байх нь зохицуулалт хийхэд хүндрэл учруулдаг. Нэг газраас нөгөө газарт нүүж шилжих нь зардал өндөртэй ч байна.

- **Цаг хугацаа ба мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийх**

Захиргааны болон удирдлагын бусад зардлыг хэн нэгэн хариуцах хэрэгтэй байдаг. Гишүүнчлэлийн хураамж (тогтмол дүнгээр буюу гишүүдийн орлогын тодорхой хувиар тооцож болох) авдаг байх хэрэгтэй. Байгууллага нь үйл ажиллагааны тогтвортой байдлаа хангах тодорхой механизмуудтай байх ёстой.



Зохион байгуулалт амжилтгүй болж уналтанд орох шалтгаан:

Аливаа байгууллагын дотор цаг хугацаа, мөнгө, удирдлага зэрэгтэй холбоотой дотоод зөрчил үүсэх буюу тэдний зохион байгуулалтанд орох анхны хүсэл сонирхлыг нэгтгэж байсан зүйл биелэгдэх, өөрчлөгдөх тэр үед зохион байгуулалт амжилтгүй болж уналтанд орох явдал гардаг. Зарим тохиолдолд байгууллага өөрийн чиглэл, хэтийн зорилгоо тогтоогоогүй байх явдал гардаг. Өөр бас шалтгаан бол байгууллагын үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл нь гишүүдийнхээ эрэлт, хэрэгцээнд нийцээгүй байх явдал ч байна. Эдгээр шалтгааны улмаас байгуулага уналтанд орж болно. Баленгсулагийн Сюринэйм тосгоны алт олборлогчид өөрийн байгууллагын тогтвортой ажиллагааг хангах үүднээс концессын удирдлагын санг байгуулсан. Тухайн олборлолт явуулж буй газар дээр ажиллаж байгаа оператор орлогынхоо 10 хувийг уг санд төлдөг байна. Байгууллага нь санд төвлөрсөн мөнгийг олон нийтийн хөгжлийн төслүүд тухайлбал хоол хүнсний хэрэгцээтэй өрх бүлийг хүнсний зүйлээр хангах, орон нутгийн сургуулиудад ном сурах бичиг нийлүүлэх, орон нутагт эмнэлэг барих зэрэг хүмүүнлэгийн болон хөгжлийн төслийн үйл ажиллагаанд зарцуулдаг байна.

Байгууллага нь өөрийн зорилго, үйл ажиллагааны хэлбэрээс хамаарч цаашид үргэлжлэх үү эсвэл үйл ажиллагаагаа зогсоох уу гэдгээ шийддэг. Заримдаа бичил уурхайчид тулгарч буй тодорхой асуудал /жишээ нь: уул уурхайн том компаниудын зүгээс тэдний үйл ажиллагаанд саад учруулах/-тай тулгарах үед тэд эрхээ хамгаалах үүднээс зохион байгуулалтанд ордог. Сюринэймд 1990-ээд оны дундуур “Гоулден стар ресурс” хайгуулын компани орж ирснээс бичил уурхайчид нэгдэн өөрсдийн байгууллагаа байгуулах болсон. Хэсэг хугацаанд ажилласны дараа



компани тус газраас маш бага хэмжээний ашиг олоод тус газрыг орхиж явсан бөгөөд уг байгууллагын үйл ажиллагаа ч зогссон байна. 2004 онд дахин өөр нэг компани олборлолт явуулахаар ирэхэд бичил уурхай эрхлэгчид дахин өөрсдийн эрх ашгийг хамгаалах байгууллагаа байгуулсан. Эдгээр хүчин зүйлээс харахад бичил уурхай эрхлэгчдийн байгууллага нь дотоод хүчин зүйл гэхээсээ илүүтэй гадны хүчин зүйлээс хамаарч байгуулагдах, үйл ажиллагаагаа зогсоо тохиолдол ч байдаг гэдгийг энд харуулж байна. Хэрэв нөлөөлж буй гадаад хүчин зүйлсийн асуудал шийдэгдэх бол тухайн байгууллага заавал урт хугацаанд оршин тогтоод байх шаардлагагүй байж болно. Гэхдээ дотоод болон гадаад аль ч хүчин зүйлтэй холбоотой үүсэн байгуулагдсан байгууллагууд нь илүү урт хугацаанд оршин тогтнож үйл ажиллагаагаа явуулж чаддаг байх хэрэгтэй.

Байгууллагаа хэрхэн байгуулдаг вэ?:

Бичил уурхайчид өөрсдийн эрх ашгийг хамгаалсан байгууллагаа байгуулах, өргөжүүлэхдээ мэдээлэл сурталчилгааны тодорхой аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулж болно. Холбогдох мэдээллийг Нэгдсэн холбоо нь радио, телевиз, сонин хэвлэлээр дамжуулж болно. Түүнчлэн бичил уурхайчдын дунд төдийлөн сайн хангалттай бус байдаг мэдээлэл тухайлбал төр засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд, дүрэм журам, төр засгийн байгуулагууд, орон нутгийн засаг захирагааны байгууллагуудын үндсэн чиг үүрэг, бичил уурхайчдын зохион байгуулалтын ач холбогдол, уул уурхай, ашигт малтмалын тухай хууль, олборлолт явуулах газрын өргөдөл гаргах журам, цэвэр аюулгүй олборлолтын арга техниктэй холбоотой мэдээллийг бий болгоход анхаарна. Ингэж үндэсний хэмжээнд үүсэн бий болсон байгууллага нь өөрийн гишүүд, бичил уурхай эрхлэгчдийн дунд илүү албан ёсоор үйл ажиллагаагаа



явуулах нөхцлийг бүрдүүлж, тогтвортой бичил уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээллийг бий болгож чадна.

Бичил уурхай эрхлэгчдийн төр засгийн зүгээс хүлээх зүйл ба албан ёсны үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг/хөнгөлөлт

Бичил уурхай эрхлэгчид нь зохион байгуулалтанд орж, албан ёсны бүртгэлтэй, ажлын үнэмлэхтэй болж, аюулгүй байдлаа ханган, татвараа төлж, үйл ажиллагаагаа албан ёсоор явуулдаг байхыг хүсдэг. ГЭВЧ тэд эргээд төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлэхийг хүлээсээр байдаг. а) олон нийтийн хөгжлийн үйлчилгээ (харилцаа холбоо, эрүүл мэнд, цагдаа гм) б) бичил уурхайн олборлолт бүхий газруудад дэд бүтэц бий болгох, в) гэмт хэрэгтэй тэмцэх, г) зээл авах, д) цэвэр аюулгүй олборлолтын аргуудаас суралцах, е) зохион байгуулалтын арга хэмжээ ё) бичил уурхай эрхлэгчдэд ажлын байртай болоход нь дэмжлэг тусламж үзүүлэхийг хүсч хүлээдэг. Бичил уурхай эрхлэгчдийн хувьд гол асуудал бол олборлолтын эрхтэй байх учир нь том уурхайн компаниуд тэдэнд энэ эрх, боломжийг төдийлөн ойлгодоггүй. Сюринэймд бичил уурхайчид олборлолт явуулах газрын зөвшөөрөл авах нь чухал байдаг учир нь ийм зөвшөөрөл аваагүй тохиолдолд албан ёсоор үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдаг. Бичил уурхай эрхчлэгчдийн хувьд албан ёсоор ажиллах нь албан бусаар ажилласнаас нэг их илүү зардал гардаггүй.

Бичил уурхай эрхлэгчид орон нутагтаа татвараа төлөх нь тэдгээрийн гэр бүл болон бусад иргэдийн амьжиргаанд тустай гэдгийг ойлгодог. Филлипинд төр засгийн газар уул уурхайн орлогын тодорхой хувийг бичил уурхай эрхлэгчдэд зориулан “Иргэдийн бичил уурхайн олборлолтыг хамгаалах



сан"-д төвлөрүүлдэг. Төр засгийн газар, бичил уурхай эрхлэгчдийн аль аль нь бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай, албан ёсоор хууль дүрмийн хүрээнд явуулж ашиг орлого олохыг зорьдог. Төр засгийн зүгээс бүртгэлтэй бичил уурхай эрхлэгчдэд ямар хөнгөлөлт урамшуулал олгож болох, шинээр батлан гаргах хуулиудад бичил уурхайгаас орж буй орлогоос тухайн иргэдэд эргүүлэн ямар хэлбэрээр ашиг хүртээх боломжтой хуулийн орчин бүрдүүлэх арга замуудыг эрэлхийлдэг.

Бичил уурхай эрхлэгчдийн тоо өндөртэй улс орнуудын төр засгийн зүгээс бичил уурхай эрхлэгчдийн зохион байгуулалт, тэдгээрийн байгууллагуудыг дэмжин хөнгөлөлт үзүүлдэг. Ганад Бичил уурхай эрхлэгчдэд Холбооны гишүүний үнэмлэхийг нь үндэслэн тоног төхөөрөмжийг импортын татваргүй худалдан авах боломж олгодог. Түүнчлэн тус орны Засгийн газар зохион байгуулалтанд орсон бичил уурхай эрхлэгчдэд геологийн ба технологийн асуудлаар дэмжлэг үзүүлдэг.

Бичил уурхай эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх төр, засгийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

Бусад орнуудын туршлагаас харахад бичил уурхайн үйл ажиллагааг албан ёсны болгоход төрийн байгууллага бичил уурхай эрхлэгчдийн хооронд сайн харилцаа холбоо тогтоох нь чухал гэдэг нь харагддаг. Бичил уурхайн асуудал хариуцсан төрийн байгууллагууд идэвхитэй ажиллаж бичил уурхай эрхлэгчдийн дунд сайн танигдах явдал чухал байна. Эдгээр байгууллагын хүмүүс нь бичил уурхай эрхлэгчидтэй байнга уулзаж санал бодлыг нь сонсч орон нутагт өөрийн салбар төлөөллийг ажиллуулдаг байх хэрэгтэй. Тус байгууллага нь бичил ба том уурхайн хүрээнд гардаг зөрчил, маргааныг шийдэх үүрэг хүлээдэг байх нь чухал. Төр, засгийн газар нь

бичил уурхай эрхлэгчдэд олборлолт явуулах зарим газрыг тусгайллан тогтоож өгдөг байх хэрэгтэй.

Төрийн байгууллагуудын зүгээс бичил уурхайн үйл ажиллагаанд оролцохгүй, ямар нэг арга хэмжээ авахгүй байх нь асуудлыг шийдэх, зохицуулахад улам бүр хүндрэл учруулна. Иймд төр, засгийн байгуулагууд бичил уурхай эрхлэгчидтэй уулзаж ярилцдаг байх нь чухал байдаг. Бичил уурхай эрхлэгчид ч бодлого боловсруулах үйл явцад оролцдог байхыг эрмэлздэг. Төр засгаас аливаа хууль дүрмийг батлан мөрдөхийн өмнө тэдгээрийн хэрэгжилтэнд талуудын оролцоог бий болгох үүднээс холбогдох асуудлаар бичил уурхай эрхлэгчидтэй уулзаж санал бодлыг нь сонсож, тусгадаг байх нь чухал.



Төр, засгийн байгууллагын ажилчид бичил уурхайчдын дунд техникийн сургалт хийж байна. Судан улс



Шүхэр байгууллага байгуулсан тухай олон улсын жишээ:

Бусад орнуудын энэ талаарх жишээг хараадаа удаан үйл явцтай зарим тохиолдолд урам хугарах ч байдал ажиглагддаг. Гэхдээ зохион байгуулалт, албан ёсны болох үйл явц нь бичил уурхайн үйл ажиллагааг хууль ёсны, тогтвортой, эдийн засгийн үр ашигтай, бичил уурхай эрхлэгчдийн амьжиргааг дэмжсэн үйл ажиллагаа болгон хувиргахад чухал ач холбогдолтой.

Перу:

Перу улс бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, албан ёсны болгох талаар сайн туршлагатай орны нэг. Тус орны бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд ороогүй учраас энэ байдал нь тэдний цаашдын хөгжин дэвжих боломжид сөрөг нөлөө үзүүлж байна гэдгийг ойлгосон. Тэд бусдын ашигт малтмалын эрхийн хүрээнд ажилладаг, өөрийн гэсэн өмчийн эрхгүй байгаа нь тэдний байр суурийг сул хэвээр байлгасаар байна гэдгийг ойлгосон. Түүнчлэн тэд өөрсдөө бие даан тусдаа ажиллах чадавхи сул хэвээр байна гэдгийг ч ойлгодог. Иймд өөрсдийн дуу хоолойгоо гаргаж талуудтай зөвшилцөн ажиллахын тулд нэгдэх хэрэгтэй гэдгийг тэд ойлгосон байна. Үүний үр дүнд тэд 1) уурхайн ажлын зохион байгуулалт, 2) нийгмийн зохион байгуулалт гэсэн 2 зохион байгуулалтын асуудлыг чухалчлан анхаарч бичил уурхай эрхлэгчдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилготой ажиллажээ.

Бичил уурхай эрхлэгчид анхнаасаа бие даан энэ ажлыг эхэлсэн болохоор тэдний хувьд байгууллага байгуулан ажиллах нь нэлээд тэвчээр шаардсан ажил байлаа. Иймд бичил уурхай эрхлэгчдэд зохион байгуулалтанд хэрхэн орох талаар сургалт зохион байгуулах, тэдэнд хамгийн сайн тохирох байгууллагыг бий болгон, ашиг тусыг нь хүртээх,



байгууллагыг үр дүнтэй ажиллуулах үүднээс чадавхи бий болгох, үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага одоог хүртэл байсаар байна.

Зохион байгуулалтыг сайжруулсаны үр дүн

Бичил уурхай эрхлэгчид өөрсдийн байгууллагатай болсоноор шинээр ашигт малтмалын олборлолтын эрх эзэмших, бусад эрх эзэмшигчидтэй байгуулах гэрээндээ ажлын нөхцлөө сайжруулах талаар хэлэлцэж ярилцдаг болсон байна. Хөгжлийн хөтөлбөрүүд тухайлбал: эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн хоол тэжээл, эмэгтэйчүүдэд зориулсан сургалт зэрэг нэн тэргүүний асуудлуудаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах боломжуудыг бүрдүүлж эхэлжээ.

Зарим газар бичил уурхай эрхлэгчид өөрсдийн компанияи байгуулж, ашигт малтмалын олборлолтын газрын эрхтэй болсон байна. Жишээ нь: Минера Моллехуака / өмнөд Америк/ 1994 онд 268 хувьцаа эзэмшигчидтэйгээр байгуулагдсан. Энэ нь Перугийн хуулиар нэг боловсруулах үйлдвэр, 5 олборлолтын газрын тусгай зөвшөөрөл эзэмших боломжтой юм. Тус компани нь өдөрт 20МТ-ийн хүчин чадалтай үйлдвэр ажиллуулдаг /уг үйлдвэрээ Канад, Японы техник хамтын ажиллагааны агентлагуудын тусламжаар барьсан байна/.

2001-2002 онд гар аргаар ашигт малтмал олборлогч иргэд нөхцөл байдалтайгаа уялдуулан “улс төрийн зориг”-той болж зохион байгуулалтанд орох, албан ёсны үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдүүлэх санал санаачлагаа төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэй хэрэгжүүлж эхэлсэн. Уг хүчин чармайлтын үр дүнд 2002 онд Бичил уурхайн тухайн хууль батлагдан гарч, бичил уурхайн байгууллага бий болж, бэхжүүлэх, чадваржуулах бичил уурхайг дэд салбар болгон хөгжүүлэхэд анхаарах болсон.



Бичил уурхайн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, бичил уурхай эрхлэгчдийн Нэгдсэн холбоог байгуулах:

2001 онд бичил уурхай эрхлэгчдийн ахлагчид бичил уурхайн бүсийн уулзалтыг зохион байгуулах санаачлагыг гаргасан. Уг уулзалтаар бичил уурхай эрхлэгч иргэдэд Бичил уурхайн тухай хуулийн төслийг танилцуулж, хуулийн төсөлд өгсөн өөрсдийн саналтайгаа уялдуулан “Зохицуулах хороо”-г байгуулсан. Тус хороо нь туршлагатай ТББ-аас дэмжлэг аван ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөгөө боловсруулан боломжит эх үүсвэрүүдээс санхүүгийн ба зохион байгуулалтын тусламж дэмжлэг авах ажлаа эрчимтэй явуулж эхэлсэн байна. Түүнчлэн тус Хороо нь бичил уурхайчдын уулзалтаар дамжуулан Эрчим хүч, уул уурхайн хороотой холбоо тогтоон, хууль эрх зүйн орчны асуудалд өөр бусад бүс нутгийн бичил уурхайчдыг татан оруулж, дуу хоолойгоо нэгтгэн хамтран ажилладаг болжээ. Тэд бүсийн хэмжээнд уулзалт ярилцлага зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн бүсийн байгуулагуудыг байгуулах ажлыг эхлүүлсэн. Бичил уурхайчдын ахлагчид Конгрессын даргад хандан дэмжлэг авах зорилготой уулзалт ярилцлагуудыг зохион байгуулж улмаар Бичил уурхай эрхлэгчдийн үндэсний зохицуулах хороо, үндэсний Нэгдсэн холбоо /AMASUC/-г байгуулсан. Бичил уурхайн хууль эрх зүйн хэрэгцээ шаардлага, эрх зүй зохицуулалтын орчинг бүрдүүлж эхэлсэн нь газар газрын/ бүс нутгуудын бичил уурхай эрхлэгчдийг нэгтгэн хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Энэхүү бичил уурхай эрхлэгчдийг нэгтгэж буй олон хүчин зүйл нь тэднийг зохион байгуулалтанд ороход хүргэж, чиглүүлж өгсөн.

Тодорхой зохион байгуулалтанд орохгүйгээр бичил уурхайн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх санаачлагaa үр



дүнтэй хэрэгжүүлж чадахгүй. Хууль эрх зүйн орчинг өөрчлөх боловсронгуй болгох гэсэн нэгдсэн нэг зорилгогүйгээр бичил уурхай эрхлэгчдийн байгууллага жинхэнэ ёсоороо бүрэлдэж чадахгүй. Бичил уурхай эрхлэгчид эрх бүхий албаны хүмүүстэй орон нутгийн болон улс төрийн түвшинд өөрсдийн санал бодлоо илэрхийлэн үр дүнтэй ярилцлага, хэлэлцүүлгийг хийдэг болох нь тэдний хувьд том амжилт байх болно.

Перугийн туршлагын ололт амжилт, сургамж:

- Тухайн үеийн "улс төрийн хүсэл зориг"-ийн давуу талыг ашигласан.
- Бичил уурхай эрхлэгчдийг зохион байгуулалтанд оруулж, ажиллуулах гэсэн тэдний ахлагч нарын идэвхи зүтгэл, туршлагатай ТББ ба бусад байгуулагуудын дэмжлэгт үндэслэсэн.
- Олон оролцогч талууд, тэдгээрийн дэмжлэг тусlamжийн хүрээнд амжилттай хэрэгжиж чадсан.



Перугийн Бичил уурхайчдын удирдааг Бичил уурхайн олон улсын хуралд дуу хоолойгоо илэрхийлж байна



Танзани

Танзанийн эмэгтэй уурхайчдын холбоо (TAWOMA) нь 1997 онд бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч эмэгтэйчүүдийн санаачлагаар байгуулагдсан бөгөөд эмэгтэй уурхайчдын ашиг сонирхлын төлөө үйлчилдэг олон нийтийн байгуулага юм. Уг холбоо нь 400 идэвхитэй гишүүдтэй ба 17 бүсийн ба 15 орон нутгийн салбартай бөгөөд уг салбарууд бүгд уул уурхайн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг газруудад байрладаг. Тус холбоо /TAWOMA/ нь өөрийн гишүүдийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлыг илэрхийлэх, түүний дотор хүүхдүүд, тэдгээрийн хамгаалал, амьжираагаа дээшлүүлэхэд чиглэдэг. Олон эмэгтэйчүүд ашигт малтмал олборлох ажиллагаанд оролцохдоо шудрага бус асуудалтай тулгарч, хүнд хэцүү, аюултай, хортой орчинд тухайлбал тоосжилт ихтэй ба мөнгөн усны ууршилт бүхий газруудад урт цагаар ажилладаг. Ихэнхи эмэгтэйчүүдийн хувьд эрх нь зөрчигдэж эрүүл мэнд, аюулгүй байдал хангагүй орчинд урт цагаар үр бүтээмж багатай ажиллаж, олборлосон ашигт малтмал, бүтээгдэхүүн буюу үйлчилгээндээ шудрага үнэ тогтоолгож чаддагүй байсан байна.

Гол үйл ажиллагаа, хүрсэн ололт амжилт

- Олборлолт, ДОХ, байгаль орчны менежмент, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах зэрэг асуудалтай холбоотой хүний эрх, эрсдэл ба эрүүл мэндэд үзүүлэх аюул заналын талаар мэдээлэл сурталчилгааны ажил явуулдаг болсон.
- Гишүүдийн дунд тусгай зөвшөөрлийг хэрхэн авах, албан ёсны олборлолт, боловсруулалт явуулах, ашигт малтмалын зах зээлийг олж авах, хамтын/ хоршин ажиллах хэлбэрүүд, хуримтлал бий болгох, зээл авах үйлчилгээ, манлайллын ур чадварууд зэрэг олон



чиглэлээр чадавхи бий болгох сургалт семинар зохион байгуулах, алт олборлогч эмэгтэйчүүд, үйлчилгээ үзүүлэгчдэд үйлдвэрлэл эрхлэх сургалт зохион байгуулдаг болсон.

- TAWOMA холбоо нь “TAWOMA Төсөл нэг” компани байгуулж, гишүүдийнхээ олборлосон ашигт малтмал/ бүтээгдэхүүнийг цуглуулан олон улсын зах зээлд нийлүүлдэг болсон.
- Гишүүд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн (өнгөт чулуунуудыг жижиглэн өнгөлөх замаар) хийх ур чадвартай болсон ба байгууллага нь өнгөт чулууг тайрч жижиглэдэг, өнгөлгөө хийдэг 1 машинтай болсон.
- Гишүүдээ олон улс /7 орон оролцсон/-ын үзэсгэлэн ба шудрага худалдааны яармагт оролцуулдаг, жил бүр ашигт малтмалын үзэсгэлэн ба Уурхайчдын өдрийг тэмдэглэдэг болсон.
- Уурхайн бүс нутагт бага зардал бүхий байшин барих ажилд эмэгтэйчүүдийг татан оролцуулсан.

TAWOMA нь үндсэндээ өөрийн гишүүдийн хандив, хураамжаар санхүүждэг. Чадавхи бий болгох ажиллагаа нь үндсэндээ TAWOMA –ийн үйл ажиллагааг дэмжин бэлэн бусаар хувь нэмэр оруулдаг хувь хүмүүс, бүлгүүдээр дамжин хэрэгждэг. Тус холбооны хамтран ажилладаг гол байгууллага нь Эрчим хүч, эрдэс баялагийн яам, Залуучуудын хөдөлмөр, ажил эрхлэлтийн яам, Олон нийтийн хөгжлийн жендер ба хүүхдийг дэмжих яам, Сангийн яам болон тус холбоотой хамтран ажилладаг DFID, НҮБХХ-ийн Эмэгтэйчүүдийг дэмжих сан, НҮБХХ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд байдаг.



Бичил уурхайчдын уулзалт

Филлипин

Бичил уурхай эрхлэгчид Холбоо ба Нэгдсэн холбоонд нэгддэг.

Нэгдсэн холбоо

Бичил уурхай эрхлэгчдийн Нэгдсэн холбоо нь бүсийн хэмжээнд байгуулагдаж, бүсийн хэмжээнд ажиллаж байгаа холбоо, хоршоодоос бүрддэг. Холбоо бүр Нэгдсэн холбоонд өөрийн төлөөлөл /ихэнхидээ холбооны ахлагчид/-ийг томилон оруулдаг. Нэгдсэн холбоо нь өөрийн эгнээнд нэгдсэн холбоодын эрх ашгийг хамгаалах бөгөөд гол чухал асуудлуудаар харилцагч, хамтрагч талууд, үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцан хэлэлцээр ярилцлагыг хийдэг. Ихэнхидээ өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг. Уг холбоо нь өөрийн гишүүд ба Уул уурхайн газар, том уурхай, орон



нутгийн засаг захиргаадын үйл ажиллагааг хооронд нь холбогч ба лобби агентын үүрэгтэй ажилладаг. Нэгдсэн холбооны ахлагч ба гүйцэтгэх гишүүд нь сайн дурын үндсэн дээр 2 жилийн хугацаатай үүрэгт ажлаа гүйцэтгэдэг. Нэгдсэн холбооны бусад чиг үүрэгт аюулгүй ажиллагааны уралдаан тэмцээн, хурал уулзалт, ярилцлага, аюул гамшгийн үед авах арга хэмжээ, аюулгүй ажиллагааны асуудал ба олборлолт явуулсан газруудад нөхөн сэргээлт явуулах ажлыг зохицуулах ажил үүргүүд ордог байна. Нэгдсэн холбооны жилийн уулзалт/хурлын үеэр уурхайчид өөрсдийн мэргэжлийн онцлогийг харуулсан жагсаал хотын төвд зохион байгуулдаг.

Байгаль орчны менежментийн үйл ажиллагаа:

Уурхайчид өөрсдийн олборлолт явуулсан газартаа нөхөн сэргээлт хийж мод тарьдаг. Филиппиний ойн аж ахуйн дүрмээр олборлолт явуулсан газарт нэг мод огтолсон бол 25 суулгац тарих ёстай ба тухайн га/талбайг нөхөн сэргээхэд бичил уурхай эрхлэгчид идэвхитэй оролцож мод тарих үүрэгтэй.

Зимбабе

Зимбабийн Уурхайчдын нэгдсэн холбоо нь бичил уурхайн дэд салбарын хэмжээнд гишүүддээ тустай олон үйл ажиллагааг зохион явуулахад маш идэвхитэй оролцдог. Нэгдсэн холбоо нь бус нутгийн хэмжээнд олборлолт явуулдаг бүлгүүд болон Зимбабийн алт олборлогчдын холбоо, Хром олборлогч уурхайчдын холбоо, Шороон ордын уурхайчдын холбоо, Эмэгтэй уурхайчдын холбоо зэрэг тусгай сонирхол бүхий бүлгүүдээс бүрддэг. Гишүүд нь хандив, хураамж төлдөг бөгөөд гишүүдийн ба бусад оролцогч талуудын дэмжлэгтэй үйл ажиллагаагаа явуулдаг.



Ололт амжилтууд:

- Нэгдсэн холбооны гол дэмжигч нь Уул уурхайн сайд.
- Мөнгөний бодлогын асуудлаар Төв банкны зөвлөлд төлөөлөлтэй ба уг төлөөлөл нь бичил уурхайн мөнгөний бодлогын орчинд санал зөвлөгөө өгч ажиллдаг.
- Баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулахдаа хувийн санхүүжүүлэгчид ба арилжааны банкуутдтай зээлийн асуудлаар харилцан үйлчилгээ авдаг.
- 2004 онд Засгийн газраас алтны үнэ, татвар, худалдан авах зөвлөмж гарган хэрэгжүүлсний дараагаар бичил уурхай эрхлэгчдийн байгууллага бараг том уурхайгаас тушаасантай адил хэмжээний алтыг Төв банкинд тушаасан (бичил уурхайгаас: 10 тн, том уурхайгаас: 11тн)
- Төр засгийн холбогдох байгуулагуудаас үйл ажиллагааны ба захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд дэмжлэг авсан.
- Гишүүдээ олборлолтын эрхтэй болгохын тулд боломжит хөрөнгө оруулагчидтай холбож өгдөг.
- 2007 онд Засгийн газраас бичил уурхайн үйл ажиллагааг хааж, байгаль орчны нөхөн сэргээлт хийх хатуу шаардлага тавьж байсан үед төр засгийн газартай бичил уурхайд ээлтэй байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаар хэлэлцэж ярилцаж чадсан.
- Бичил уурхай эрхлэгчид өөрсдийн санал бодол, асуудлаа улс төрийн эрх бүхий хүмүүст хүргэж тавьдаг болсон.

Нгези –бичил уурхай эрхлэгчдийн хоршоо

Энэ хоршоог 100 гаруй бичил уурхай эрхлэгчид нэгдэн байгуулсан бөгөөд гишүүд нь өмнө уг бизнес ба хромын том уурхайд ажиллаж байсан хүмүүс байна. Хоршоо



олборлолтын зөвшөөрлөө аваад эхэн үедээ хүдрээ гар аргаар олборлон гаргаж авдаг байсан ч аажимдаа компрессор, цохилтот өрөм зэрэг багаж төхөөрөмж хэрэглэн ачааны машин ашигладаг болсон. Эрдэс баялагийн яамны Уул уурхайн газрын тусламжтай тэд хромын гүний уурхайг албан ёсоор ашиглахад зээл авсан. Зөвлөх үйлчилгээг Яамны Уул уурхайн газар өгдөг болсон. Хайлуулах үйлчилгээ эрхэлдэг компаниудтай харилцаа тогтоон үйлдвэрлэлээ тогтмол явуулдаг болсон. Уг хоршоо нь өөрийн 10 гишүүнийг гүний уурхайн олборлолтын сургалтанд хамруулсан байна.



Дүгнэлт

Дээр өгүүлсэн олон улсын бичил уурхайчдын байгууллагын сайн туршлага, сургамжийн талаар үншиж судлаад манай бичил уурхайчдын үүсгэн байгуулсан ТББ-ууд үүсэн байгууллагдаж эхэлсэн 2008 оноос эхлэн өнөөдрийг хүртэлх хугацаанд явуулсан үйл ажиллагаа, хөгжлийн үйл явцыг эргэн нэг харцгаая.

Эдгээр ТББ-ууд анх байгуулагдах үед бичил уурхайн талаарх нийгэм дэх олон нийтийн ойлголт, хандлага маш сөрөг, эрх зүйн орчин бүрдээгүй байсан, уул уурхайн үйлдвэрлэлд мөнгөн усны хэрэглээг хориглосон нь олон уурхайчдын амьжиргаанд нөлөөлсөн зэрэг гадны хүчин зүйлээс шалтгаалан бичил уухайчид зохион байгуулалтанд орж, нэгдэх, дуу хоолойгоо нэгтгэн орон нутаг, уул уурхайн компанитай тохиролцоонд хүрэхийг эрмэлзэн идэвх санаачлагатай ажиллаж байсан. Ийм ч учраас ТББ-ууд тодорхой үр дунд хүрч чадсан. Гэсэн хэдий ч сүүлийн үед эдгээр ТББ-ууд ямар нэг хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байсан боловч зарим ТББ-ын хувьд урьдах амжилтаяа бататгах биш харин гишүүдийн идэвх нь суларч, үйл ажиллагаа нь тогтвортгүй, байнгын биш, байгууллагын оршин тогтонох чадавхийг бэхжүүлээгүй, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах талаар дуу хоолойгоо нэгтгэж, хүчирхэг нөлөө бүхий байж чадаагүйгээс орон нутгийн засаг захирагааны байгууллага, уул уурхайн компаниудаас төдийлөн дэмжлэг авч чадахгүй байна. Мөн түүнчлэн дотоод хүчин зүйлийн нөлөөнөөс тухайлбал, байгууллагын дотоодын зөрчил, удирдлагадаа итгэх итгэл алдarsан зэргээс шалтгаалан ТББ-ууд жинхэнэ утгаараа шаардлагын хэмжээнд ажиллаж чадаагүй байна. Гэхдээ энэ үзэгдэл нь зөвхөн бидэнд тулгарсан асуудал биш бусад орны бичил уурхайчдын байгууллагад ч тохиолдож байсан сургамж ажээ. Иймд бичил уурхайчдын ТББ-ууд



үйл ажиллагаагаа эргэн харж, өөрсдийн болон олон улсын бичил уурхайчдын байгууллагын зохион байгуулалтын туршлага, сургамжаас суралцан, дүгнэлт хийж үйл ажиллагаагаа тогтмолжуулан идэвхжүүлэх, чадавхижих, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах байгууллагын бүтэц, зохион байгуулалттай болох хэрэгцээ шаардлага гарч байна.

Бичил уурхайн чиглэлээр тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хувьд ТБҮТ-ийн зүгээс бичил уурхайчдын Үндэсний хэмжээний нэгдсэн бичил уурхайчдын холбоо байгуулах хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна:

1. Бичил уурхайг хөдөө орон нутагт ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, орлого бүрдүүлэх цаашилбал хүний хөгжлийг дэмжих, хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч болгохын тулд,
2. Бичил уурхайчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах, бичил уурхайн нөхөрлөлүүд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа болон тэдгээрийн үүсгэн байгуулсан ТТБ-ын үйл ажиллагааг дэмжих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, дуу хоолойгоо нэгдсэн байдлаар хууль тогтоогч, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч наарт хүргэхийн тулд,
3. Бичил уурхайн талаар баримтлах төрийн бодлого, шийдвэр гаргах, хууль тогтоомжийг боловсруулахад бичил уурхайчдын санаа бодлыг тусгах, оролцоог хангахын тулд,
4. Бичил уурхайчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх донор байгууллагуудтай холбоо тогтоох, уялдаа холбоог хангах, үйл ажиллагааны чиглэлийг давхардуулахгүй байлгах, үр дүнд чиглэсэн нягт



хамтын ажиллагаа бий болгохын тулд,

5. Монголын болон гадаад орны бичил уурхайчдын сайн туршлага, хуримтлуулсан мэдлэг мэдээлэл, сургамж, техник технологийг бичил уурхай бүхий орон нутагт түгээн дэлгэрүүлэх, бичил уурхайн тогтвортой хөгжлийг хангахын тулд,
6. Бичил уурхайчдыг бичил уурхай тойрсон зөрчлийг зохицуулах, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай, аюул осолгүй үйл ажиллагаа явуулах чадвартай болгох, бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэхийн тулд,
7. Тэдний оролцоо, эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд,